



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/71/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улиастай сум 2022 он	Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn Аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч : Г.Заяа Утас:92038288 Цахим хаяг: zayag@audit.gov.mn Аудитор:Ц.Алтантуул Утас: 91195554 Цахим хаяг : tuul9565@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12

2022. 02. 21 № 1302/83
танай _____ -ны № _____ -т

ЭРДЭНЭХАЙРХАН СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Н.СОСОРБУРАМ-д

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

013022966

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ

АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	63.52	71.69
35	БАРАА МАТЕРИАЛ	63.52	71.69
351	Түүхий эд материал	40.96	48.60
35110	Тусгай зориулалттай материал	40.35	48.08
35130	Эм боох материал	0.61	0.52
354	Хангамжийн материал	22.56	23.09
35410	Бичиг хэргийн материал	6.71	6.78
35420	Аж ахуйн материал	9.27	9.38
35440	Түлш, шатах тослох материал	0.50	0.50
35460	Хүнсний материал	2.50	2.81
35470	Бусад хангамжийн материал	3.58	3.62
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	753.28	714.33
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	753.28	714.33
392	Биет хөрөнгө	693.67	655.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	688.37	688.37
39202	Хуримтлагдсан элэгдэл	(81.47)	(103.21)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	27.34	27.34
39204	Хуримтлагдсан элэгдэл	(17.31)	(20.56)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	152.25	154.54
39206	Хуримтлагдсан элэгдэл	(132.35)	(139.97)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	68.49	68.49
39208	Хуримтлагдсан элэгдэл	(49.84)	(56.62)
39214	Бусад үндсэн хөрөнгө	47.76	47.76
39215	Хуримтлагдсан элэгдэл	(31.20)	(35.41)
39217	Ном	21.64	24.31
393	Биет бус хөрөнгө	59.62	59.29
39301	Програм хангамж	2.03	2.03
39302	Хуримтлагдсан элэгдэл	(0.38)	(0.71)
39303	Бусад биет бус хөрөнгө	57.97	57.97
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	816.80	786.02
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	816.80	786.02
51	Засгийн газрын хувь оролцоо	816.80	786.02
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	559.72	559.72
51101	Өмч: - төрийн	559.72	559.72
512	Хуримтлагдсан үр дүн	(126.80)	(157.58)
51210	Өмнөх үеийн үр дүн	(126.80)	(126.80)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(30.79)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	383.88	383.88

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	816.80	786.02
---	--	--------	--------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансн ы код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	601.59	623.04
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	19.37	9.25
120	Нийтлэг татварын бус орлого	19.37	9.25
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	19.37	9.25
120004 5	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	18.57	9.25
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	582.23	613.79
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	511.47	497.52
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	511.47	497.52
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	70.76	106.92
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	70.76	106.92
1330	Төсвийн захирагчдаас	-	9.35
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	9.35
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	618.37	653.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	618.37	653.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	571.21	636.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	377.09	396.79
210101	Үндсэн цалин	377.09	396.79
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48.42	52.16
210201	Тэтгэврийн даатгал	32.36	36.53
210202	Тэтгэмжийн даатгал	4.02	3.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	3.21	3.13
210204	Ажилгүйдлийн даатгал	0.80	0.78
210205	Эрүүл мэндийн даатгал	8.03	7.81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	72.19	105.71
210301	Гэрэл, цахилгаан	2.47	3.09
210302	Түлш, халаалт	69.72	102.62
2104	Хангамж, бараа материалын зардал	8.42	7.60
210401	Бичиг хэрэг	2.62	2.82
210402	Тээвэр, шатахуун	2.86	1.66
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1.40	3.12
2105	Нормативт зардал	15.69	24.37
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.84	0.73
210502	Хоол, хүнс	14.85	23.64
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.18	1.21
210604	Урсгал засвар	0.18	1.21

2107	Томилолт, зочны зардал	0.56	0.72
210702	Дотоод албан томилолт	0.56	0.72
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.46	0.80
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	0.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48.19	46.76
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2.46	2.84
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	45.73	43.92
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47.15	17.72
2132	Бусад урсгал шилжүүлэг	11.28	17.72
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5.06	12.59
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	4.62
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6.22	0.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(16.77)	(30.79)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(19.40)	(30.79)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	559.72	383.88	(126.80)	816.80
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	559.72	383.88	(126.80)	816.80

D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	559.72	383.88	(126.80)	816.80
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(30.79)	(30.79)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	559.72	383.88	(157.58)	786.02

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	583.02	613.79
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	582.23	613.79
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	511.47	497.52
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	511.47	497.52
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	70.76	106.92
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	70.76	106.92
1330	Төсвийн захирагчдаас	-	9.35
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	9.35
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	576.90	612.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	576.90	612.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	531.60	591.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	377.09	396.79
210101	Үндсэн цалин	245.82	217.79
210102	Нэмэгдэл	105.21	146.24
210104	Урамшуулал	26.06	32.76
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48.42	52.16
210201	Тэтгэврийн даатгал	32.36	36.53
210202	Тэтгэмжийн даатгал	4.02	3.91

210203	ҮОМШӨ-ний даатгал	3.21	3.13
210204	Ажилгүйдлийн даатгал	0.80	0.78
210205	Эрүүл мэндийн даатгал	8.03	7.81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70.76	106.75
210301	Гэрэл, цахилгаан	2.47	3.09
210302	Түлш, халаалт	68.29	103.66
2104	Хангамж, бараа материалын зардал	8.45	5.20
210401	Бичиг хэрэг	1.30	1.09
210402	Тээвэр, шатахуун	2.99	1.52
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2.61	2.60
2105	Нормативт зардал	18.84	24.06
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2.30	0.64
210502	Хоол, хүнс	12.96	20.95
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3.58	2.48
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	0.17
210604	Урсгал засвар	-	0.17
2107	Томилолт, зочны зардал	0.56	0.72
210702	Дотоод албан томилолт	0.56	0.72
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.46	0.80
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	0.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7.02	5.09
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7.02	5.09
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45.29	20.72
2132	Бусад урсгал шилжүүлэг	9.42	20.72
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3.20	15.60
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	4.62
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6.22	0.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	6.12	1.32
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	6.12	1.32
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6.12	1.32
2200	Дотоод эх үүсвэрээр	6.12	1.32
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6.12	1.32
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(6.12)	(1.32)

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	609.10	604.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	609.10	604.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	592.99	588.34

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	396.79	396.79
210101	Үндсэн цалин	217.79	217.79
210102	Нэмэгдэл	146.24	146.24
210104	Урамшуулал	32.75	32.76
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52.16	52.16
210201	Тэтгэврийн даатгал	37.37	36.53
210202	Тэтгэмжийн даатгал	3.70	3.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	2.96	3.13
210204	Ажилгүйдлийн даатгал	0.74	0.78
210205	Эрүүл мэндийн даатгал	7.40	7.81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	110.53	106.75
210301	Гэрэл, цахилгаан	6.25	3.09
210302	Түлш, халаалт	103.32	103.66
2104	Хангамж, бараа материалын зардал	5.51	5.12
210401	Бичиг хэрэг	0.99	1.01
210402	Тээвэр, шатахуун	3.29	1.52
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.55	2.60
2105	Нормативт зардал	24.00	24.06
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.65	0.64
210502	Хоол, хүнс	20.95	20.95
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2.40	2.48
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1.00	0.17
210604	Урсгал засвар	1.00	0.17
2107	Томилолт, зочны зардал	0.84	0.72
210702	Дотоод албан томилолт	0.84	0.72
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.40	0.80
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.40	0.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1.77	1.77
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	16.10	16.10
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15.60	15.60
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.50	0.50
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	609.10	604.44
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	497.57	497.52
131001	Улсын төсвөөс санхүүжих	497.57	497.52
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	111.53	106.92
132001	Орон нутгийн төсвөөс	111.53	106.92
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	32.00	32.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	21.00	21.00
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		9.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ		9.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		4.73
2104	Хангамж, бараа материалын зардал		0.08
210401	Бичиг хэрэг		0.08
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		4.65
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		4.62
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		4.62

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Эрдэнэхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Интер Аудит ХХК-ийн гэрээт аудитор Ц.Алтантуул гүйцэтгэж, хяналтыг Интер Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Мөнхбаяр, Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежерийн үүрэг гүйцэтгэгч Г.Заяа, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Эрдэнэхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Эрдэнэхайрхан сумын Ерөнхий боловсролын сургууль нь хүүхэд бүрийн оролцоо, сурах үйлийг дэмжиж, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгахад эцэг эх, олон нийтийн хамтын ажиллагааг нэмэгдүүлснээр сурлагын амжилтыг ахиулж хоцрогдлыг нөхнө.

- ✓ Зорилт 1: Хүүхдийн сурлагын түвшнийг тогтоож, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилган, сургуульдаа дасан зохицох үйлийг дэмжихэд сургууль, эцэг эх, олон нийтийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх
- ✓ Зорилт 2: Хүүхэд бүрд хоцрогдлоо нөхөж, өөрийн удирдлагатай хамтран суралцаж хөгжих, оролцоог тэгш хангах, бие даан үр дүнтэй суралцах арга барилыг төлөвшүүлэх
- ✓ Зорилт 3: Эрүүл ахуйн зөв дадал, хэвшилтэй сургууль болох
- ✓ Зорилт 4: Багш нар хичээл сургалтын үйл ажиллагаандаа хосолсон сургалтын арга зүйг туршин ажиллах
- ✓ Зорилт 5: Багш суралцагчдын үндэсний бичгээрээ унших, бичих чадварыг сайжруулах зорилго тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрддөггүй

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторроос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 613.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 9.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

дд	Дансны нэр	Тайлант оны эхний үлдэгдэл	Тайлант оны эцсийн үлдэгдэл	Зөрүү
1	БАРАА МАТЕРИАЛ	63,519.54	71,692.20	(8,172.67)
2	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	753,283.93	714,325.49	38,958.44
4	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	816,803.47	786,017.69	30,785.78
5	Засгийн газрын хувь оролцоо	816,803.47	786,017.69	30,785.78
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	816,803.47	786,017.69	30,785.78

Бараа материалын данс 8,172.67 мянган төгрөгөөр өссөн нь цаг үеийн шаардлагаар мах худалдан авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 38,958.44 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны элэгдлийн зардал өндөр тооцогдсонтой холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 30,785.78 мянган төгрөг болж буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 609,095.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 609,095.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 497,519.6 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 106,916.8 мянган төгрөгийн нийт 604,436.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 604,436.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд 9,350.9 мянган төгрөгийн нэмэлтийн орлого бүрдүүлэн, 4,623.2 мянган төгрөгийг хөдөө орон нутагт ажилласан багшийн тэтгэмжид, 4,649.5 мянган төгрөгийг хичэл үйлдвэрлэлийн зардалд 78.1 мянган төгрөгийг бичиг хэргийн зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.8 Аудитын гол асуудал

Сангийн сайдын 190-р тушаал болон Засгийн газрын 43-р тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 111 мэдээлэл, хугацаа хоцроосон 38 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэхэд шилэн дансанд мэдээлэл байршуулахдаа хугацаа хоцроосон байгаад анхаарч ажиллах шаардлагатай байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллагад ашиглагдаж байгаа хөрөнгийн бүртгэлд тавих дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 2.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 3.4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

4.2 Төлбөрийн акт

Засгийн газрын 43-р тогтоолыг зөрчин 2.4 сая төгрөгийн төсвийн хөрөнгөөр бэлтгэлийн хувцас худалдан авч ажилтнуудад олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

4.3 Албан шаардлага

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

- ✓ 3.4 сая төгрөгийн зардлыг эдийн засгийн ангиллаар зарцуулаагүй

1.2. Өгсөн зөвлөмж:

- ✓ Сангийн сайдын 190-р тушаалыг хэрэгжүүлэн ажиллах

Дээрх акт, албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

1.	Эрдэнэхайрхан сумын Ерөнхий боловсролын сургууль	2	5.8			1	2.4			1	3.4
----	--	---	-----	--	--	---	-----	--	--	---	-----